

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны  
Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн  
.../40 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Хэдэн удаа	Нийт үнэ /төгрөгөөр/
1.	"Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ын төсөл боловсруулах зөвлөхийн үйлчилгээний зардал /1 хүн ажлын 40 хоног/	85,000	1	40	3.400.000
2.	Төслийг танилцуулах, хэлэлцүүлэгт оролцогчдын цайны зардал	12,000	25	2	600.000
3.	Дүн				4.000.000

- Хүүхдийн эрхийн чиглэлээрх Монгол Улсын хууль тогтоомжууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, түүний нэмэлт протокол, зөвлөмжүүдтэй уялдуулан журмыг шинэчлэн боловсруулна.
- Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт холбогдсон, гэрч, хохирогч болсон хүүхдэд үзүүлэх үйлчилгээг хэн, хэрхэн үзүүлэх талаар тодорхойлох;
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, шинэчилсэн төсөлд нөлөөллийн шинжилгээ хийнэ.

#### **Гүйцэтгэх ажил, үйлчилгээ:**

- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлж, саналыг тусган, хэлэлцүүлгийн тэмдэглэл, саналын товъёгийг үйлдэнэ.
- Нөлөөллийн шинжилгээг хийнэ.
- Шинэчилсэн журмыг хэрэгжүүлэх талаар арга зүйн сургалт 1 удаа зохион байгуулна.

#### **Зөвлөхөд тавигдах шалгуур үзүүлэлт:**

1. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар сүүлийн хоёр жилийн хугацаанд судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байсан ажлын туршлагатай байх.
2. Зөвлөхийн боловсрол, эрдмийн зэрэг цол, ажлын туршлага, ажилласан жил, төрийн бус байгууллагад хийж гүйцэтгэсэн ажлын туршлага зэрэг нь харгалзан үзэх үзүүлэлт болно.

#### **Хяналт, тайлагналт:**


- Зөвлөх нь захиалагчтай байгуулсан гэрээний дагуу ажиллах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын удирдлага, холбогдох мэргэжилтэнтэй байнга холбоотой ажиллана.
- Гэр бүлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газар нь зөвлөхийн ажлын явц, үйл ажиллагаанд нь саад болохгүйгээр ямар ч үед хяналт тавих эрхтэй.
- Зөвлөх нь ажил гүйцэтгэж буй гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөөний талаар гэрээнд нарийвчлан тусгах бөгөөд ажлын гүйцэтгэлийн тайланг явцын, эцсийн гэсэн 2 удаагийн үр дүнгээр ирүүлнэ.
- Ажлын гүйцэтгэлийн эцсийн тайланг гэрээт ажил дууссанаас хойш 5 хоногийн дотор **Гүйцэтгэх ажил, үйлчилгээ** хэсэгт заасан ажлыг бичгээр болон цахимаар хүлээлгэн өгнө.

#### **Хугацаа:**

Дээрх ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг дуусталх хугацаанд гүйцэтгэнэ.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
яамны Төрийн нарийн бичгийн даргын  
2021 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн  
№140 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



“Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж

### Үндэслэл:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг үндэслэн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/51, А/69 хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг арга зүй, удирдлагаар ханган ажиллаж байна.

Гэмт хэргийн хохирогч, холбогдогч, сэжиглэгдэн шалгагдаж байгаа хүүхдийн эрхийг хууль шүүхийн хүрээнд хамгаалах, зөвлөн туслах чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2017 оноос аймаг, дүүрэг бүрт байгуулагдан, 2017 онд 618 хүүхдэд, 2018 онд 897 хүүхдэд, 2019 онд 902 хүүхдэд, 2020 онд 862 хүүхдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, хүүхдийн боловсрол эзэмшиж, нийгэмшиж төлөвших эрхийг нь хамгаалж ажиллажээ.

Энэ нь Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн 56.4%-д үйлчилгээ үзүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл, гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор 8000 хүүхэд тутамд 1 хүүхдийн байцаагч байхаар тооцож, “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-т өөрчлөлт оруулан, 140 хүүхдийн байцаагчийн орон тоог бий болгон ажиллаж байна.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт холбогдсон, гэрч хохирогч болсон хүүхэд бүрт шаардлагатай эрх зүйн туслалцааг үзүүлж, нийгэмшүүлэхэд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

### Зорилго:

“Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-д нөлөөллийн шинжилгээ хийж, шинэчлэн сайжруулж боловсруулах

### Гүйцэтгэх ажлын хүрээ.

Зөвлөх нь дараах ажлын хүрээг анхаарч ажиллана. Үүнд: